

Нэрт эрдэмтэн, сурган хүмүүжүүлэгч проф.Д.Батсуурийн Монголын боловсрол, шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэр

Б.Бурмаа

МУИС, ФЭС, Физик боловсролын тэнхим

ТОВЧ НАМТАР

Манай орны анхны физикч эрдэмтэдийн нэг, ахмад сурган хүмүүжүүлэгч Д.Батсуурь 1925 оны 8-р сарын 15 –д Завхан аймгийн Сонгино сумын нутагт ард Дамбаравжаагийн 5-р хүү болон төрж таван хүү дөрвөн охинтой өнөр өтгөн айлийн гэр бүлд өсчээ. 1935 онд Түдэвтэй сумын бага сургуульд орж улмаар Улаанбаатар хотын 1-р арван жилд шилжин суралцаж байгаад 1942 МУИС-ийн бэлтгэл ангиаар дамжин МУИС-ийн багш нарын факультетийн физик- математикийн салбарт суралцан 1947 онд төгөссөн.

Батсуурь багш 1947 оны 7-р сард физикийн ангийг төгсөн их сургуульдаа багшаар үлдсэнээс хойш МУИС-д багш, тэнхимийн эрхлэгч, дэд захирал зэрэг албыг насан эцсээ хүртэл хашин, МУИС-ийн түүхийг бүтээж, бичилцсэн манай сургуулийн хүндтэй, гавъяатай, түүхэн хүмүүсийн нэг билээ. Монгол улсын боловсрол, шинжлэх ухааны ууган төв болох МУИС-тай өөрийн үйл амьдралаа 45 жилийн турш холбон, МУИС-ийн баялаг амьдралын олон талт үйл ажиллагаанд идэвхи, чармайлт гарган манлайлан оролцож байсан багшийн маань үйл ажиллагааг энэхүү илтгэлд бүхэлд нь багтаах боломж мэдээж тун бага юм.

Д. Батсуурь багшийн монголын шинжлэх ухаан, боловсролд оруулсан хувь нэмэрийг дараах хэдэн чиглэлээр товч гаргахыг хичээлээ.

Нэг. Проф. Д.Батсуурь нь Монгол оронд физикийн боловсролыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, сурган хүмүүжүүлэгч багш хүн юм.

Проф. Д.Батсуурь нь монгол оронд дээд боловсролтой физикийн багш, физикчидийг бэлтгэх сургалтын үйл ажиллагааны тулгын чулууг тавилцсан ахмад үеийнхэний эгнээнд зүй ёсоор ордог. 1960 онд Физикийн тэнхимийг Онол туршлагын физикийн тэнхим болгон өөрчлөх үед багш маань хамт олныхоо хүндэтгэлийг хүлээн анхны эрхлэгчээр сонгогдон 1970 он хүртэл арван жилийн турш удирдан ажилласан юм.Тухайн үед ОТФ-ийн тэнхим нь физикийн салбарын цорын ганц тэнхим байсаны хувьд өмнөх илтгэлүүдэд дурьдагдсан физикийн

сургалтыг шинэчлэхтэй холбоотой бүхийл үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байсан.Тухайн үеийн ОТФ-ийн тэнхимд ажиллаж байсан багш нар ШУТИС, ЭМИС, ХААИС гэх мэт манай орны олон дээд сургуулиудад физикийн тэнхимийг үндэслэн байгуулсан юм. Батсуурь багшийг тэнхим удирдаж байх үед физикийн салбарын оюутны ширээнд сууж байсан залуучуудаас манай орны физикийн салбарын нэртэй эрдэмтэд, бүх шатны сургуулийн чадалтай сайн физикийн багш нар, үйлдвэр, үйлчилгээний газрын чадвартай инженерүүд төрөн гарсан юм. Ийнхүү МУИС-ийн физикийн салбарыг төгөссөн үе үеийн олон зуун шавь нарын хувьд Батсуурь багш маань эрдэм ном заасан, тэд нарын хүндэтгэл хайрыг хүлээсэн багш хүн байсан юм.

Хоёр. Проф. Д. Батсуурь нь монгол оронд хатуу биеийн физикийг үндэслэгч эрдэмтэн юм.

Батсуурь багшийн эрдэм, судлалын ажлын талаар өмнөх илтгэлд дэлгэрэнгүй тусгагдсан учир би энд цөөн хэдэн үг хэлье. Батсуурь багш 1953-1957 онд Москвагийн улсын их сургуулийн физикийн факультетийн аспирантурт суралцахдаа 1895 онд үл мэдэгдэх цацраг гэсэн нэртэйгээр эрдэмтэдийн гайхалыг төрүүлж, 1901 онд нээсэн эрдэмтэндээ Физикийн салбарын анхны Нобеллийн шагналыг авчран, нэрийг хүний нь мөнхжүүлсэн, физикчидийн “үнэний төлөө эрэл хайгуул”-ийн нэг гол олол болох рентген цацрагийг ашиглан бодисийн доторхи атомуудын орон зайн байрлал, тэнд гарсан гажигийг судлах чиглэлээр ажилласан байна. Ингээд “Рентген цацрагаар цэвэр металлын кристалл торын гэмтэл судлах” сэдвээр физик- математикийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалж хээрийн галуу үл хүрэх газраас өвгөн Дамбаравжаагийн хүү эрдмийг өвөрлөн ирсэнээр хатуу биеийн физикийн салбарт манай улсын анхны эрдэмтэн төрсөн юм.

Багш маань рентген бүтцийн анализийн чиглэлээр лекц уншиж, семинар удирдан, шаардлагатай багж төхөөрөмж бүхий лабораторийг шинээр буй болгон, хатуу

биеийн физикийг сонирхосон оюутнуудын курс, дипломын ажлыг удирдан, өөрийн шавь нарыг бэлтгэж эхэлсэнээр хатуу биеийн физикийн шавь сургуулийнхаа тулгын чулууг тавьсан билээ.

Хатуу биеийн физикийн хамтлагын анхны гишүүд нь Г.Шилагарьди, С.Доржханд, Б.Бурмаа, Х.Дорж, С.Цэрэнчимэд, М.Баатархүү, Д.Сангаа, Б.Намжилдорж, С.Батдэмбэрэл, С.Даваасамбуу зэрэг Батсуурь багшаар эрдэм, ном заалгасан гарын шавь нар нь байсан. Багш маань эрдэмтэн хүний алсын хараагаар судалгааны шинэ чиглэлийг нээж, өнөөдрийн нийгмийн амьдралыг тодорхойлж байгаа электроник, мэдээлэл хариуцааны технологийн үндсэн материал болох хагас дамжуулагч материалыг судлах болсоноор гадаад орны, нэртэй их сургуулиудыг төгссөн Л.Оюунбилэг, С. Чадраабал, Жаргал, П.Алтанцог, З.Болд, С.Саран, С.Энхтөр зэрэг олон залуучууд манай хамтлагт орж ирсэн юм. Батсуурь багшийн хамгийн ойрын өмөг түшиг нь болж байсан анхны гарын шавь нар болох С.Доржханд, Х.Дорж нар ШУА-ын хатуу биеийн тасгийг ээлжлэн удирдаж Н. Энэбиш, Д.Агчбаяр, Д. Начин, Т.Галбаатар, Ш.Төмөрбаатар, Г.Сэвжидсүрэн, Баяннасан, Мөнхсайхан, Нарангуяа зэрэг олон залуучуудаар эгнээгээ өргөжүүлэн ажиллаж ирлээ.

МУИС –д проф. Д.Сангаа багшийнхаа үндсэн мэргэжил болох рентген бүтцийн анализийн чиглэлээр сургалт, судалгааны ажлыг үргэлжлүүлж, лабораторийг орчин цагийн багаж төхөөрөмжөөр тоноглон, судалгааны шинэ аргуудыг эзэмшин, гадаадын эрдэмтэдтэй тогтоосон хэлхээ холбоог улам өргөгсөн ажиллаж байна.

Өнөөдөр Батсуурь багшийн анхны шавь нар нь ш/у ба боловсролын өндөр цол хэргэмтэй, өөрийн гэсэн бүтээлтэй, шавьтай ахмад эрдэмтэд болшгоосон бөгөөд, дунд үеийнхэнээс Проф. Док. Д. Сангаа ШУА –ын ФТ-ийн хүрээлэнгийн захиралаар, Док. П.Алтанцог хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар, Док. Батдэмбэрэл ШУТИС-ийн материал судлалын профессорын багийн ахлагчаар, З.Болд МУИС-ийн МЗ-ийн сургуулийн захиралаар Док. С.Даваасамбуу Герман улсад Макс-Планкийн хүрээлэнд төслийн удирдагчаар, Н.Энэбиш, Д.Начин нар төрийн байгууллагад хариуцлагатай алба хаших зэргээр энэхүү хамтлагт хамрагдаж байсан залуучууд зах зээлийн ороо босгоо үед бүгд тодорхой ажил төрөл эрхлэн багшийнхаа

эхлүүлсэн ажил, үйлсийг шинэ нөхцөлд, шинэ арга барилаар үргэлжлүүлж байна.

Гурав. Д.Батсуурь нь Монголын шинжлэх ухааны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан эрдэмтэн юм.

1970-90 онуудад МУИС-ийн эрдэм шинжилгээний ажлын цар хүрээ далайц ихээхэн өргөжин, дэлхийн их сургуулиудын жишигт дөхөж очиход тус дөхөм болсон олон арга хэмжээнүүд авагдсан нь тухайн үед МУИС-ийн эрдэм шинжилгээний ажлыг хариуцсан дэд захиралаар ажиллаж байсан проф. Батсуурийн үйл ажиллагаатай шууд холбоотой байдаг юм.

МУИС-ийн хэмжээнд эрдэм шинжилгээний ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, байгал ба нийгмийн ухааны олон салбаруудад улсын төлөвлөгөөт суурь болон хавсрага судалгааны ажлыг эхлүүлж, аспирантурын алба байгуулан, багш нарын мэргэжил дээшлүүлэх, аспирантурт суралцуулах ажлын цар хүрээг тэлэх зэрэг олон шинэ ажлууд эрч хүчтэйгээр эхэлсэн.

Энэ үед Эрхүүгийн Улсын Их Сургуультай хамтарсан Хөвсгөл, Сэлэнгийн сав газарын байгалийн нөөцийг иж бүрэн судлах экспедиц, Эрхүүгий УИС, Политехникийн дээд сургуультай хамтарсан Хэрлэнгийн геологийн экспедиц, Герман улсын Халлегийн их сургуультай хамтарсан Ховд аймагт минж нутагшуулах судалгаа зэрэг МУИС-ийн залуу эрдэмтэд гадаадын өндөр мэргэжилтэй эрдэмтэдтэй мөр зэрэгцэн ажиллаж, ухаан бодлоо уралдуулах боломж олгосон, олон хүнийг хамарч, удаан хугацааны туршид үргэлжилсэн эрдэм судлалын үйл ажиллагааг эхлүүлэн хэрэгжүүлсэн нь МУИС-ийн эш –ний ажлын түвшин, цар хүрээг өндөрт өргөсөн юм. 1980-аад онд аж ахуйн гэрээгээр хийх эш –ний ажлын хүрээ өргөжиж, сургалт, судалгааг амьдрал үйлдвэрлэлтэй холбоход ихээхэн ахиц гарч байжээ.

МУИС-ийн хэд хэдэн салбарт үндэсний мэргэжилтэн эрдэмтэдийн шавь сургуулийн эхлэл тавигдаж, оюутнуудыг судалгааны экспедиц, гэрээт ажил зэрэгт татан оролцуулж, ирээдүйн эрдэмтэдийг бэлтгэж эхэлсэн бөгөөд 1973 оноос оюутны шилдэг бүтээл шалгаруулах болсон.

“ МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг” “Эрдэм шинжилгээний сонсгол мэдээ” зэрэг сэтгүүлүүдийн чанар сайжирч, өөрийн орны эрдэмтэдийн бүтээлийг гадаад, дотоодод сурталчлах болсон.

Б.Батсуурь багш МУИС-ийн эрдэм шинжилгээний ажлыг 1970-аас эхлэн хорь гаруй жил удирдахдаа энэ ажилд зөвхөн албан тушаалаар ногдсон үүрэг хариуцлагаа биелүүлэх төдийхнөөр хандаж байгаагүй. Их сургуулийн багш нарын хувьд эрдэм шинжилгээний ажил нь оюуны өндөр мэдлэг чадвар, сонирхол тэмүүлэлээс гадна санхүүгийн хүрэлцээтэй боломж, удирдлагын мэдрэмжтэй дэмжлэг шаардсан ихээхэн түвэгтэй хэцүү ажил байдаг.

Манай сургуулийн олон салбарт хаврын турихан яргуй шиг соёолон хөгжиж эхэлсэн эрдэм судлалын ажилд оролцогчдыг дэмжиж, зоригжуулж, зовлон жаргалыг нь хуваалцаж, тэднийг мэдэрч, урам өгч хамтран ажиллаж байсан дотоод гадаадын хүмүүст нэр хүндтэй, нөмөр нөөлөгтэй эрдэм судлалын ажлын авъяаслаг зохион байгуулагч орлогч захиралаа, тухайн үед түүний өрөөгөөр хөлхөлдөн, бужигнаж байсан олон хүн дурсаж байдаг. Тэдгээрийн тэргүүн эгнээнд энэ танхимд сууж байгаа УИХ-ын эрхэм гишүүн, Академич Авдай, гавьяат багш Жамсран нэр зүй ёсоор орно.

Дөрөв. Д.Батсуурь нь МУИС-ийн гадаад харилцааг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан ардын дипломат юм.

Батсуурь багш маань МУИС-ийн дэд захиралын албыг хашиж байх хугацаандаа эрдэм шинжилгээнээс гадна гадаад асуудлыг хариуцаж, МУИС-ийн гадаад харилцааг хөгжүүлэхэд их хувь нэмэр оруулсан юм. Энэ үед

МУИС нь Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургууль, Эрхүү хотын их сургууль, Хунбольтын Нэрэмжит Берлин хотын их сургууль, Халле Витгенбергийн Мартин Лютерийн нэрэмжит их сургууль, ХБНСЮУ-ын Белградын их сургууль, БНКУын Гавана хотын их сургуулиудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, хамтарсан судалгаа явуулах, багш, оюутан солилцох зэрэг үйл ажиллагааг өргөжүүлсэн.

Гадаадын нэр хүндтэй өндөр түвшиний төлөөлөгчид манайд сургуульд айлчлах, хариуцлагатай үйл ажиллагааг чадварлаг зохион байгуулдаг байсан. НҮБ-ийн ерөнхий нарийн бичгийн дарга Курт Вайлдхам, Харвьер Перес де Куэльбер, ЮНЕСКО-гийн ерөнхий захирал Амаду Махтар Боу, Дубнагийн ЦШНИ-ийн захирал Н.Н. Боголюбов, МоУИС-ийн ректор Р.Б. Хохлов нарын айлчлалыг зохион байгуулж, 1970 он хүртэл манай сургуулийн

хүндэт доктор ганц хүн байсан бол эдгээр хүндэт зочид манай сургуулийн хүндэт доктор болцгоосон юм.

Тав. Проф. Д.Батсуурь олон нийтийн зүтгэлтэн хүн байсан юм.

Батсуурь багш маань МУИС-ийн орлогч захирал байсан үедээ зөвхөн эрдэм шинжилгээ, гадаад харилцаанаас гадна сургуулийн хэмжээнд явагддаг олон үйл ажиллагаанд идэвхитэй оролцон шууд зохион байгуулж ажилладаг байсан.

Жил бүрийн намар МУИС-ийн төв байрын өмнө талд дэвшээ өндрөлсөн ачааны машины цуваа байрлаж, инээд баясалаар дүүрсэн оюутан залуучууд, багш нар хөнжил пүүгээгээ үүрэн гүйлдэж, радиогоор ургацын далай нэвтрүүлэг ” Алтан намрыг ” уяангалуулдаг сайхан үйл явдал болдог байжээ. Та нар эх орондоо хайртай бай, гэсэн үгийг анги танхимд хэдэн мянга дахин хэлсэнээс ч илүү мэдрэмжийг оюутан залуучуудад буй болгож тэдэнд эх орноороо бахархах, амьдрал, бүтээн байгуулалтанд оролцох олон талт чадварыг төлөвшүүлж байсан намрын тариа хураалтын ажилд оролцох МУИС-ийн цувааг орлогч захирал Батсуурь багш дотор нь суусан машин түрүүлэн явдаг байсаныг олон хүн санаж байгаа байхаа. Аж ахуйн газрын захиалга, хүсэлтийг сайн биелүүлж тэдэнтэй түншийн холбоо тогтоох, оюутан, багш нараа бороо тусахгүй орон байранд оруулж, бор ходоодыг нь өлсгөхгүй байх, машин тэрэгний авар осол гаргуулахгүй байх зэрэг эрдэмтэн хүний хувьд хэт түвэгтэй, аж ахуйн үйл ажиллагааг Батсуурь багш маань олон жилийн турш чадварлаг зохион байгуулж байсан.

Дэлхийн 2-р дайны хүнд жилүүдэд оросын ард түмний дэмжлэг, оросын эрдэмтэдийн хүч хөдөлмөрийн оролцоотойгоор үүсэн хөгжсөн МУИС-ийн хувьд орос монголын ард түмний найрамдалт хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хувь нэмэрээ оруулах нь нэр төр, ёс зүйн асуудал байдаг. Энэ үйл хэрэгт Батсуурь багш маань МЗНН-ийн төв зөвлөлийн гишүүн, МУИС-ийн МЗНН-ийн салбар зөвлөлийн дарга зэрэг сонгуульт үүргийг хүлээн тодорхой хувь нэмэрээ оруулж байсан.

Зургаа: Төгсгөл

Академич Д.Батсуурийн хөдөлмөр бүтээлийг үнэлэж доцент, профессор, академич зэрэг эрдмийн өндөр цолыг олгож, Алтан гадас одон, Болгарын 1300 жилийн ойн медал зэрэг төрийн одон медалуудаар удаа дараа

шагнаж байжээ. Гэхдээ хүн бол авсан гавъяа шагналаасаа илүүтэйгээр өөрийн гэсэн онцлогтой эерэг имижийг бүрдүүлэн байж хүмүүсийн сэтгэлд тодорхой орон зай эзлэн, мөнхөрч, дурсагддаг юм байна гэдгийг Багшийн маань 80 насны ойд зориулсан арга хэмжээнүүдийг бэлтгэхэд хүчин зүтгэсэн шавь нар, үр хүүхэд, хань ижил, ах дүү садан, хамтран зүтгэгч олон хүний санал, бодол, дурсамж, үйл ажиллагаа харуулж байлаа.

Батсуурь багшийг танихгүй, түүнийг хараагүй залуучуудын хувьд энэ их ажлыг нугалж, амжуулж байсны хувьд энэ хүн ажлаас өөр зүйлийг мэдэж, анхаардаггүй байсан байхдаа гэсэн сэтгэгдэл төрж болох юм. Тэгвэл бас тийм биш.

Манай багш маань өмсөх хувцасаа бол өнгөний зохицуулалт, дизайны мэдлэгтэйгээр тохируулан цэвэр цэмцгэр хувцасладаг, эрүүл чийрэг биетэй, үс зүс сайхангай, их сургуулийн царайлаг бүсгүйчүүдийн анхаарал, харааг татсан, физикчид биднийхээ доторхи Юндэн гөөгөө байсан юм.

Багш маань даргын голдуу ажлыг хашиж байсан боловч хүнийг дээр дор, хөгшин залуу гэж ялгадаггүй, ажлын бус цагаар найз нөхөдтэйгээ дариваж аяга тагш юмыг амсчихдаг, загас жараахай хөөцөлдөж, волейбол шатар тоголчихдог, машин тэрэг жолоодчихдог, олон хүүхдийн халамжит аав, өрхийн тэргүүлэгч, эгэл жирийн эр хүн байсан юм.

Багш маань бүтээл тууривал нь эд цэцэглэж байсан үедээ ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн боловч түүний тулгын чулууг тавьсан их үйлсийг үе үеийн шавь нар нь цааш үргэлжлүүлэн хөгжүүлж байгаагийн нэг тод илрэл нь багшийнхаа мэндэлсэний 80 жилийн ойд зориулан энэхүү арга хэмжээнүүд юм.

Багш дор мөргөм үү

Ном дор мөргөм үү

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.